

Жамбын Дашдондог

МЭРГЭН
ЗУРАВ



Жамбын ДАШДОНДОГ



МЭРЭЭН
ЭҮРЭВ

Улаанбаатар 2007 он





рт урьдын цагт гэнэ
Энэхэн замбуу тивд гэнэ

Араар дүүрэн адуутай
Өврөөр дүүрэн үхэртэй
Хоолой дүүрэн хоньтой
Хадаар дүүрэн ямаатай
Говиор дүүрэн тэмээтэй
Баяндай өвгөн гэж
Байсан юмсанж.
Гэтэл нэгэн өдөр
Гэнэт урьдаас нь
Гэрийн чинээ гэдэстэй
Тогоон чинээ толгойтой
Таван алдын ташаатай
Арван алдын алхаатай
Атгаалжин хар мангас
Ангалзан гарч ирээд:
-Ай, өвгөн
Адуу малдаа хайртай юу?
Аль эсвэл
Амь биедээ хайртай юу? гэжээ.

Урт буурал сахлаа
Шувтарч нэг үзээд
Ухаант Баяндай өвгөн
Шууд л ингэж хэлжээ.
-Аа, би
Адуу малдаа хайртай
Амь биеийг минь
Авбал ав даа!
Харин намайг
Хараадай мэргэний
Хатааж ширээсэн
Хатан илднээс ондоо
Юу ч даадаггүй
Юм шүү дээ, хө! гэв.




Атгаалжин хар мангас
Ангалзан алхалсаар
Хараадай мэргэнд очиж
Хатан илдийг нь гуйжээ.
Хараадай мэргэн
Хар сахлаа илэн:
-Хатан илдээ өгье л дөө
Харин түүнийг
Шараадай мэргэний
Шандас сайтай
Шарга азарганаас ондоо
Юу ч тээдэггүй
Юм шүү дээ хө! гэв.



Атгаалжин хар мангас
Ангалзан алхалсаар
Шараадай мэргэнд очиж
Шарга азаргыг нь гуйжээ.
Шараадай мэргэн
Шар сахлаа илэн:





-Шарга азаргаа өгье л дөө
Шандаст түүнийг
Цагаадай мэргэний
Цагаалж хийсэн
Цагаан уурганаас ондоо
Юугаар ч барьдаггүй
Юм шүү дээ, хө! гэв.

Атгаалжин хар мангас
Ангалзан алхалсаар
Цагаадай мэргэнд очиж
Цагаан уургыг нь гуйжээ.

Цагаадай мэргэн
Цагаан сахлаа илэн:
-Цагаан уургаа өгье л дөө
Гагцхүү түүнийг
Гадаад далайн чанадаас
Аваад ирнэ гэдэг л
Амаргүй хэрэг дээ! гэв.

Атгаалжин хар мангас
Ангалзан асуусан нь:
-Гадаад далайг яаж
Гаталдаг юм бэ?
Цагаадай мэргэн
Цагаан сахлаа илэн:





-Толгойноосоо
Том хар чулуу зүүгээд
Бугуйнаасаа
Бул хар чулуу уяад
Гадаад их далайг
Гаталдаг юм даа!
Гайхамшигт уургыг
Авчирдаг юм даа! гэв.



Өнөө мангас
Өвгөний хэлснээр
Толгойноосоо
Том хар чулуу зүүгээд
Бугуйнаасаа
Бул хар чулуу уяад
Гадаад далайд оржээ
Гарч чадалгүй живжээ.

Хараадай
Шараадай
Цагаадай гурав
Хамтарч
Эвсэж
Нэгдэж байж
Аюулаас нөхрөө
Аварсан санжээ
Амар сайхандаа
Жаргасан санжээ.



Ж.Дашдондог
МЭРГЭН ГУРАВ


Монгол ардын үлгэрээс сэдэвлэв
Нэгдүгээр ангийнханд зориулав

| | |
|----------------------|-------------|
| Зураач: | М.БУЯН |
| Хянан тохиолдуулсан: | С.ЭНХЖАРГАЛ |
| Дизайныг: | Т.ДЭЛГЭРМАА |
| Хянагч: | Ж.Гэрэлмаа |



Хэвлэл нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.